



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/76

Мөрөн сум

Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт
шилжүүлсэнтэй холбогдуулж
авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Засгийн газрын 2024 оны 62 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1.Өвөлжилт, хаваржилт хүндэрсэнтэй холбогдуулан зудын эрсдэлийг бууруулах, хаваржилтын хүндрэлийг хохирол багатай даван туулах зорилгоор аймгийн хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллагыг 2024 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 15-ны хүртэлх хугацаанд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2.Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т заасан арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг сумдын Засаг дарга, аж ахуйн нэгж, байгууллагын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3.Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай

3.1.Мал аж ахуйн салбарт үүсээд буй нөхцөл байдал, хаваржилтын хүндрэлийг хохирол багатай даван туулах зорилгоор “Малчдадаа тусалъя аян”-ыг аймаг, сумын хэмжээнд зохион байгуулахыг бүх шатны Засаг дарга нарт даалгасугай.

3.2.Аймаг, сумдын шуурхай штабт ажиллаж буй төрийн албан хаагчдын цалин, илүү цагийн хөлсийг тооцож олгох, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах тусгайлсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Шуурхай штаб (М.Хуягбаатар)-т даалгасугай.

3.3.Малын сэг, зэм устгахад шаардагдах ариутгал, халдваргүйтгэлийн бодис, гоц халдварт өвчний вакцин, шаардлагатай эм бэлдмэлийн нөөц бүрдүүлэх, татан авах, орон нутагт хүргэх ажлыг шуурхай зохион байгуулахыг Мал эмнэлгийн газар (Л.Ариунаа)-т үүрэг болгосугай.

3.4.Цасанд боогдсон зам, давааг чөлөөлөх, шар усны үерт өртөж болзошгүй малчин айл өрхийг нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулахыг

6712010270

2.


аймгийн Онцгой байдлын газар (С.Ганболд)-т, Хөвсгөл АЗЗА ХХК-
(Б.Галбадрах)-д нарт тус тус үүрэг болгосугай.

3.5.Малчдад эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх, шаардлагатай
тохиолдолд газар дээр нь мэргэжлийн баг томилон ажиллуулах, эмнэлгийн
яаралтай тусламжийн бэлэн байдлыг хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газар
(М.Мөнх-Аюуш)- үүрэг болгосугай.

3.6.Хүнсний тусламж, малын тэжээл хуваарилах, хяналт тавих ажлыг шуурхай
зохион байгуулахыг Хүнс, Хөдөө аж ахуйн газар (Я.Эрхэмбаяр), Онцгой
байдлын газар (С.Ганболд) нарт тус тус даалгасугай

4.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын
Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ